



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 136

Улаанбаатар хот

┌ Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх ┐  
└ тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай ┘

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ворлд проспер ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлөө арилгаж, энэ талаар Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдээгүй тохиолдолд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авахыг “Ворлд проспер ББСБ” ХХК /Т.Уянга/-д анхааруулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

